

ACTA MONGOLICA
CENTRE FOR MONGOL STUDIES
National University of Mongolia

Том. 3 (215)

2004

73-76

Малын зүс заасан үгсийн тухай

Ч.Батсүрэн (Хүмүүнлэгийн Ухааны Их Сургууль)

Монгол хэлний үгийн сан арвин. Өнгө, зүс, царай, нүүр, түрүү гэх зэрэг ойролцоо утгат үг олон буй. Бас зүг хорших гайхамшигтай боломж монгол хэлэнд элбэг. Хоршсон үг зөвхөн хэл яриа баяжуулах төдийгүй найруулгад онцгойлон нэлөөлж яруу сонсголонтой болгох чухал шинж чанар оршосон байдаг. Дээр дурдсан үгс хэдийгээр ойролцоо утга илтгэдэг авч өөрийн гэсэн өмчийн ноогдолт утга буй нь тодорхой. Ухаан нь өнгө гэвэл харандаа, цаас, будаг шунх, даалимба даавуу сэлтэд илүү ойртож өнгийн харандаа, улаан өнгийн будаг, хар өнгөтэй дээл, саарал өнгөтэй байшин гэх мэтээр ярьж бичдэг.

Зүс хэмээвээс ихэнхдээ мал хүйтай холбогдоод ирдэг. Монголчууд малаа зүс нийлүүлж унаж эдлэн тэрэг чарганд хөллөдөг уламжлалтай.

Ягаан зүсмийн үнээ, борлог зүстэй үрээ, тарлан зүстэй хайнаг гэхээс, ягаан өнгөтэй үнээ, борлог өнгөтэй үрээ, тарлан өнгөтэй хайнаг гэдэггүй.

Царай гэвэл ихэнх тохиолдолд хүний ишийн зүйлст хамаарна. Тийм учир шар царайтай, бор царайтай гэх зэргээр ярьж бичнэ. Иймээс дээр иш татсан цөөн үгэнд өөрийн гэсэн үгийн сангийн утга буй ажээ. Энэ талаар эрдэмтэн мэргэдийн онол сургаал, тайлбар ч буй. Харин хоршиж өөр үтэй дүйлгээд ирэх үед аль аль тал руугаа бие биеийн өмчийн утга санааг улам тэлдэг ажээ. Ухаан нь: өнгө зүс алдаад миний охин яагаа вэ. *Muu хүү минь ойрноос бүүр царай зүс ороод гэх мэт.*

Мөн өнгө зүсний холбоотой түрүү хэмээх үг бий. Монголчууд малаа зүсэлж бүртгэж тоолдог. Олон зуун хоньтой айл оройд хотлуулахын өмнө ерөнхийд нь ажин зүсэлж бүртгэнэ. Нэг бүрчлэн тоолохгүй ч гэсэн баримжаалаад бүртгэчихдэг сонин увидас бий. Зожиг, хоцордог, тасардаг, содон ааш авиртай малыг голчилоод бүртгээд харахаар баримжаа тод болдог. Аж төрөхүй ёсны арга ухаан өөр өөр, нүүдэлч малч аж төрөлд хүн, малын хоорондын харилцаа, малаа таньж мэдэх, эрдэм ухаан, ааш аягийг нь олох содон сонин увидас шингэсэн байдаг.

Түрүү гэж малын нүүрэн хэсгийн нэр. Ихэвчлэн хонины зүсэнд хамаарна. Зүсэнд хамаатай олон үгс бий.

Хээр хөдөө, уул хангай, зэлүүд нутагт бэлчээрлэж яваа мал сүргээ зүслэн тодотгоно. Үлгэрлэвээс таван цагаантай гучад адуу, их дэлтэй хар азарттай хориод адуу гэх мэт. Ийнхүү алсаас хараад л зүсэнэ.

Монгол хэлний үгийн санд нэлээд жин дардаг олон үг хэллэг мал аж ахуйтай холбоотой байдаг. Түүний дотроос зөвхөн зүстэй уялсан цөөвтөр үгийн онцлогийг ажигласнаа илтгэе. Бидний анзаарснаар монгол хэлэнд малын зүстэй холбоотой үг хэллэгт нилээд содон сонин олон онцлог байна. Үүнд:

1. Зөвхөн малд хэрэглэдэг бусад зүйлд оролцдоггүй үг хэллэг бий. Үүнд: хээр, цавьдар, хул, зээрд, шарга, хундан, орог гэх мэт.
2. Малын зүсний зарим үг хэллэг бусад өнгөтэй дүйдэггүй.
Жишээ нь: улаан, ногоон (зарим нутагт загал, хар саарал адууг ийн нэрлэнэ)
Бор адуу, бор ямаа, бор хонь, бор саарал гэвэл даавуу, будаг мэт бусад өнгө заасан үгстэй дүйдэгийг дурдсу.
3. Малынхаа бие эрхтний тэр хэсэгт орших өнгөөр зүсэнэ.
Жишээ нь: магнай халзан, бөөр алаг, өсгий цагаан, сартай (ихэвчлэн адуунд хэрэглэнэ.) хар, хээр, хул, хонгор зүсмийн адуу сартай байх тохиол элбэг.
4. Малынхаа бие байдлын онцлогоор зүсэлдэг. Үүнд: хялман (цагаан нүдтэй буюу нүд хөмсөг цайвар) түнжин (үхэр, эвэргүй мухар ч гэдэг) лэг (том бөхтэй тэмээ, яаж ч таргалсан бөх нь ширээлдэггүй) Тэмээний бөх лэг байх тохиол төрмөлийн том байхаас гадна, эдэлгээний явцад гэмтээнээс болох ч тал бий. Далиу, хоовон, солжир, эвэрт (үхэр), сэлмэн эвэрт (ямаа, хайнаг) бөгтрөгтэй (үхэр, адуу) ууцан сүүлт (хонь) молцогт (ямаа, хонь ихэвчлэн молцогтой байдаг ч заримдаа бусад малд тааралдана) үүт (үү адуунд л элбэг)...
5. Монгол хэлний үгийн санд хоршоо үг олон байдаг. Малын зүсний үгэнд ч мөн нэгэн адил энэ талын үг, хэллэг арвин бий. Харин ийм үг хэллэг адуутай холбоотой зүйлст илүү олон тохиолддог. Үүнд: улаан буурал, хар хээр, хар халтар, цагаан цэнхэр, бор хээр, улаан зээрд, хар саарал, хөх саарал, улаан хээр, ухаа ягаан, мөн бусад эд агуурс хийгээд амьтны зүстэй дүйцүүлэн нээрлэх ч бий. (зандан хүрэн-тэмээ, буган халиун-адуу)
6. Малын зүсний зарим үг нийт сүрэгт бус зөвхөн тэр л малын харьят байдаг. *Борлог (адуу), тарлан (үхэр), орог (ямаа), хундан (хонь), хув (хонь, ямаа).*

Түрүү хэмээх үг зөвхөн хонинд хамаатай. Хонины чихнээс урагшхи өнгийг заан нэрийднэ. Үүнд: хар, шар, бор, хөх түрүүтэй хонь гэнэ. Энэ нь яван явсаар хүний холбоотой үг

хэллэгт ч орсон тааралдана. (толгой түрүүгүй загнах) гэх мэт. Мөн тариан түрүү гэнэ. Угтаа тэргүүн толгой хэмээх үтэй гарвал ойр утгыг агуулсан энэ үг малын зүс, тэр дундаас хонины зүстэй холбогдож нэлээд олон хувилбараар нэрийдсэн тааралддаг.

7. Малынхаа үс ноосны онцлогоор нэрийдэн зүсэлсэн байdag Жишээ нь: шанхан дэлт, бөөн сүүлт, сойлгот (бүгд адуунд хамаарна), савгат (сарлаг) ноолуурт (ямаа), зогдорт (тэмээ) гэх мэт.

8. Мөн зан, ааш авираар нь нэрлэн зүсэлнэ. Жишээ нь: ярдаг хүрэн (тэмээ) ороо шарга, уургын цэнхэр, хашин хээр, зүтгээ улаан (бүгд адуу) гувшаа хөх, дэлүүрдэг халзан (хонь, ямаа) ...

9. Үр төл өсөх үржих онцлог ашиг шимиийн байдлаар зүсэлнэ. Шиврээ гунж, хайдаг улаан, (үхэр, тэмээ) ууган халиун, хэнз хүрэн, тэлээ хар гэх мэт.

10. Явдал хөдөлгөөнөөр нэрлэнэ. Энэ нь ихэнх тохиолдолд адуунд хамаатай. Монгол хэлний үгсийн санд зөвхөн адууны явдалтай холбоотой үг хэллэг хэдэн зуугаар бий. Жишээ нь: арилжаа цэнхэр, сайвар бор, хатирч хонгор, шороо улаан, агсам халтар гэх мэт.

Малын өнгө зүсний нэр томъёонд зөвхөн тэр л малын тухай үг хэллэг элбэг тааралддаг. Ийм үг хэллэг өөр малд төдийлөн тохиолдохгүй. Үүнд:

Адуу: хээр, цавьдар, ногоон, зээрд, бор алаг, хээр алаг, хар хээр, хар халтар, улаан буурал, усан цэнхэр.

Хонь: Халзан, хар халзан, бср халзан, хар хүзүүт, улаан хүзүүт хөх хүзүүт, хар нүдэн, бор нүдэн, улаан нүдэн, хөх нүдэн, хар түрүүт, бор түрүүт, улаан түрүүт, хөх түрүүт, хундан, хув, таг, хар толгойт, бор толгойт, улаан толгойт.

Ямаа: орог, зэгэл, манхан, хар халзан (бүх бие хар зөвхөн магнай халзан) хөх халзан.

Үхэр: Улаан (адууны улаантай дүйхгүй), ягаан (адууны ягаантай дүйхгүй), хар тарлан, улаан тарлан, бор тарлан, мөн эврээр нь далиу, хоовон, муйлан саран, солжир, мухар, түнжин гэнэ.

Тэмээ: зандан, хүрэн, улаан, цагаан, хар, бор, мөн бөхөөр нь лэгширээ, солбио, холбоо, соёо, ханан, гэх зэрэгээр нэрлэнэ, зүслэнэ.

Бод малаа уналга, ачилганд голлон хэрэглэдэг учир элдэв гэм согог тусах байдал гардаг, түүгээр нь мөн нэрлэсэн байdag. Үүнд: олойрт (адуу).

Малын зүс заасан үг хэллэг монгол орны өргөн уудам нутагт ерөнхийдөө адилавтар авч, зарим нэг үг зөрөх тохиол бий. Жишээлбэл:

Ногоон морь Хэнтий, Төв аймгийн орчим энэ зүсийг илүү их хэрэглэж байхад, Хөвсгөл, Архангай зэрэгт огт хэрэглэдэггүй ажээ.

Малын зүсний тухай үг хэллэг, монгол хэлний үгийн санд нэлээд өвөрмөц онцгой байр эзэлдэг. Зүс заасан үг, зүслэж нэрлэсэн үг хоёр ч хоорондоо ялгаатай. Жишээлбэл бор морь, улаан гүү гэж эзэн нэрлэвч гадны хүн харахад цагаан харагдана. Үүнд: олон жил бор, улаан зүстэй байж байгаад сүүлийн хэдэн жил хорвоогийн жамаар мөн л өтөлж өвгөөд цайсан аж. Эзэн олон жилийн зүсээр нь ийн зүслэн нэрлэсэн учир “нэрий нь” сольж чаддаггүйд гол онцлог оршино.